



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2020 оны 6 сарын 25 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцож,  
үнэмлэх олгох тухай


Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 74.3 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.9 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 16 дугаар тойрогт Ардчилсан Намаас нэр дэвшиж 18578 сонгогчийн санал авсан Бөхчулууны Пүрэвдоржийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсугай.

2. Бөхчулууны Пүрэвдоржид Монгол Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлсүгэй.

ДАРГА *Ч. Содном* Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Ц. Болдсайхан* Ц.БОЛДСАЙХАН



00000767